

АРВАЙХЭЭР СУМЫН ОНГИ 13 ДУГААР БАГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТСҮРЭНГИЙН  
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

| Д/д                                                                                      | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                                               | Шалгуур үзүүлэлт                           | Гүйцэтгэлийн түвшин |              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                          | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэл тийн хувь |
|------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------|---------------------|--------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-------------------------|------------------|
|                                                                                          |                                                                                                                                |                                            | Суурь түвшин        | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин, биелэлт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Хүрэн түвшин, биелэлт    |                         |                  |
| 1                                                                                        |                                                                                                                                | 2                                          | 3                   | 4            | 5                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | 6                        | 7                       |                  |
| Зорилт 1. “Дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах” |                                                                                                                                |                                            |                     |              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                          |                         |                  |
| 1.                                                                                       | 1.1. Тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэх.                                                                              | Хяналтад авсан заалтын хэрэгжилтийн хувиар | 90                  | 100          | Багийн Иргэдийн нийтлэг эрх, ашиг сонирхлыг илэрхийлж, Монгол Улсын Засгийн газрын, Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалт, хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комисс, Аймаг, сумын Онцгой комиссын шийдвэрийг тухай бүрт цаг алдалгүй багийнхаа иргэдэд сурталчилан таниулах ажлыг зохион байгууллаа. Хууль тогтоомж лавламжийн санд нийт 25 эрх зүйн акт, үүнээс шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо 3, эрх зүйн лавлагаа мэдээлэл өгсөн иргэдийн тоо 315, боловсруулсан гарын авлага 2 хийсэн байна. Эрх зүйн мэдээлэл лавлагааны дийлэнх хувийг Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Иргэний хууль, цахим шилжилттэй холбоотой иргэдийн цахим ур чадвар хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлийн зөвлөгөө мэдээлэл бусад хууль тогтоомжууд эзэлж байна. | 2024.01.01<br>2024.12.31 | 100                     |                  |
|                                                                                          | 1.2. “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийг сурталчлах. Улаанбаатар, Эрдэнэт, Дархан болон бусад хотуудаас шилжин ирж байгаа өрхийн | Зохин байгуулсан арга хэмжээний тоогоор    | -                   | 1            | Нээлттэй Өвөрхангай хөтөлбөрийн хүрээнд Улаабаатар, Эрдэнэт, Баянхонгор зэрэг аймаг, нийслэлээс шилжин ирсэн 23 өрхийн сургууль, цэцэрлэгийн насны нийт 31 хүүхдийг сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | 2024.01.01<br>2024.12.31 | 100                     |                  |
|                                                                                          |                                                                                                                                | Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувиар            | 90                  | 100          | Тайлант хугацаанд Улаанбаатар, Эрдэнэт, Баянхонгор зэрэг аймаг, нийслэлээс 23 өрхийн 49 иргэн тус багт шилжин ирж, суурьшсан байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | 2024.01.01<br>2024.12.31 | 100                     |                  |

|                                                                                                          |                                              |      |     |   |                          |     |
|----------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------|------|-----|---|--------------------------|-----|
| хүүхдүүдийг хамран сурах тойргийн ЕБС, СӨБ-д хамруулах.                                                  | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар            | -    | 100 |   | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
| 1.3. "Цахим шилжилтийг эрчимжүүлэх" зорилтод жилийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.         |                                              |      |     |   |                          | 91  |
| 1.4. "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөнийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах, хэрэгжилтийг ханган ажиллах. | Зохион байгуулсан хэмжээний тоогоор          | арга | 2   |   | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
|                                                                                                          | Сургалт, мэдээлэлд хамрагдсан өрхийн тоогоор | 10   | 20  |   | 2024.01.01<br>2024.12.31 | 70  |
| 1.5. Багийн хэмжээнд улирал бүр нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж нэгдсэн                              | Зохион байгуулсан хэмжээний тоогоор          | арга | 4   | 3 | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |



|                                                                                                     |                                                                 |     |     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |                          |     |
|-----------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|-----|-----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----|
| хог тээврийн хуваарийн дагуу хог ачилтад хяналт тавих                                               |                                                                 |     |     | гэсэн нэртэй бүх нийтийн их цэвэрлэгээ ажилттай зохион байгууллаа. Дэлхийн Сайн үйлсийн өдрийг угтан өсвөр үе залуучууд, хүрээлэн буй орчноо сайжруулах, ахмад настанд тусламж үзүүлэх, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалж хог хаягдлаа цэвэрлэх зорилтод бүлгийн гэр бүл, залуучуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулагдлаа. Хог ачилт, тээвэрлэлтийн хуваарьт хяналт тавьж, иргэдээс ирсэн гомдол, саналыг тухай бүрд шийдвэрлэж ажиллаж байна.                            | 2024.01.01<br>2024.12.31 | 80  |
| 1.6. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлыг дэмжиж, хамтран ажиллах.    | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор                        | 2   | 2   | Агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр багийн шахмал түлш хэрэглэж буй 20 өрхөд угаар мэдрэгч суурилуулсан. Манай баг нь төвийн баг болохоор байр ихтэй, уурийн зуур ихтэй тул уурын зуухнуудад байнга холбогдох мэргэжилтэнтэй хамт хяналт шалгалт хийж байна.                                                                                                                                                                                                                       | 2024.01.01<br>2024.12.31 | 80  |
| 1.7. Малчдын болон, тариаланчид чадавхжуулах ажил зохион байгуулах,                                 | Сайжруулсан шахмал түлшийг хэрэглээнд нэвтрүүлсэн өрхийн хувиар | 5   | 10  | Багийн хэмжээнд шахмал түлш хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн байгаа бөгөөд одоогоор шахмал түлш ирээгүй байгаа болно                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | 2024.01.01<br>2024.12.31 | 80  |
| 1.8. Өвөлжилтийн бэлтгэл хангуулах төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор                        | 00  | 1   | Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор МУЗГ-ын 2024 оны 166 дугаар тогтоолоор баталсан "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг талаарх мэдээллийг малчдад сурталчилж, хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэх заавар, бүрдүүлэх материалыг хагас жилийн мал тооллогоор 15 өрхөд тарааж, мэдээлэл өгч ажилласан. | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
| 1.9. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бичил бизнес                                                   | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар                               | 100 | 100 | Төлөвлөгөөг 4 бүлэг 8 заалтын дагуу байгуулж үүнээс 6 заалт бүрэн хэрэгжсэн 100 хувьтай, 2 заалт эрчимжүүлэх шаардлагатай 70 хувийн гүйцэтгэлтэй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                  | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
|                                                                                                     | Төсөл хөтөлбөрт суулчилж, сургалтад                             | 3   | 5   | Малжуулах төсөлд хамруулахаар журам шаардлага хангасан 1 өрхийн материалыг бүрдүүлэн, ХХҮГ-т хүргүүлж ажилласан. Байнгын ажилд 9 иргэнийг                                                                                                                                                                                                                                                                                                                                                | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |



|                                                                               |                                                                              |                                                                             |     |           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                          |     |
|-------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------|-----|-----------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----|
|                                                                               | эрхлэгчдийг төсөл хөтөлбөрийн сургалтад хамруулах, зуулчлах.                 | хамруулсан хувиар                                                           |     |           | холбон зуучилсан. Өшгөгч рестоараны үйлчлэгч 1, Янзага цайны газарт угаагч 2, үйлчлэгч 1, тогооч 1, "Дэлгэрэх хүнсний үйлдвэрт үйлчлэгч 2, манаач 1, тогооч 1 нийт 9 иргэн хамрагдав.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                          |     |
|                                                                               |                                                                              | Төсөл хөтөлбөрт хамруулсан иргэний хувиар                                   |     |           | Нийтийг хамарсан ажилд 4, улирлын чанартай ажилд 3, нийт 7 иргэнийг холбон зуучилсан. Нийтийг хамарсан ажил сэг зэм цэвэрлэх 2, мод тарих 2, улирлын чанартай ажилд "Өв гурван лут" компаний барилгын ажилд өрөгч 2, цахилгаанчин 1 хамруулан ажиллав.                                                                                                                                                                                                                                                                                                            | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
| <b>Зорилт 2. "Хууль болон бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах"</b> |                                                                              |                                                                             |     |           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                          |     |
| 2.                                                                            | 2.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилж, хэрэгжилтийг ханган ажиллах.   | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар                                           | 100 | 100       | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 1-р улиралдаа шинэчлэн батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2024.03.28-ны өдөр Засгийн газрын 2017 оны 67, 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журамд зааснаар 16:00 цагт улс орон даяар гамшгийн зарлан мэдээллийн дуут дохио дуугаргаж, дадлага, сургууль хийгдлээ. 67 иргэн, 5 техник Биеийн тамир спортын газрын гадна талбайд цуглаж багийн ажлын албанд бүртгүүлэн заавар, зөвлөмжийн дагуу гамшгаас хамгаалах дадлага, сургуулилтад хамрагдсан. | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
|                                                                               | 2.2. Өвөрхангай аймгийн анхан шатны Улаан Загалмай хороотой хамтран ажиллах. | Шинээр сайн дурын идэвхтэн гишүүдүүд элсүүлсэн иргэний тоогоор              | 2   | 5         | 2023-2024 оны өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан аймгийн Улаан загалмайн хороотой хамтран зорилтот бүлгийн 7 малчин өрхөд өргөн хэрэглээний хүнсний тусламж үзүүлсэн. Тайлант хугацаанд шинээр сайн дурын идэвхтэн гишүүн элсүүлж, гишүүнчлэлийн татварыг төвлөрүүлж ажиллаж байна.                                                                                                                                                                                                                                                                               | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |
|                                                                               | 2.3. Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж, хамтран ажиллах.            | Гэрээний хэрэгжилтийн хувиар<br>Үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэний хувиар | 80  | 100<br>30 | Нарны дөш өрхийн эрүүл мэндийн төвтэй 2024 онд 3 зүйл 9 заалтын дагуу хамтран ажиллах гэрээний биелэлт 90 хувьтай хэрэгжиж байна.<br>Нөхөн үржихүйн 15-49 насны эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх эхэ үзлэгт 125, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 41, хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт 135, чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт 78, артерийн гипертензийн эрт илрүүлэгт 96, элэгний хорт хавдрын илрүүлэг болон В,С вирус 340 иргэн                                                                                                                              | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |



|                                                                                                                                  |                                                             |     |     |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                          |     |  |  |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|-----|-----|--|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----|--|--|
|                                                                                                                                  |                                                             |     |     |  | хамрагдсан. 0-5 насны хүүхдийн өндөр, жингийн хэмжилтэд 280 хүүхэд хамрагдсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                          |     |  |  |
| <b>2.4.</b> Мал эмнэлгийн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, хамтран ажиллах.                                              | Гэрээний хэрэгжилтийн хувиар                                | 80  | 80  |  | 3 зүйл 7 заалт бүхий хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж мал сүргийг эрүүлжүүлэх ажил эрчимтэй, тогтмол хийгдэж байна. Хэрэгжилтийн хувийг дүгнэж үзвэл 55 хувийн гүйцэтгэлтэй хангалттай бүрэн хэрэгжиж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | 2024.01.01<br>2024.12.31 | 100 |  |  |
